



БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН БОДЛОГЫН
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГВА

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БАЯРСАЙХАН

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар: 230901062

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичиг;- Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа -2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичиг;- Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.6, 6.1.7-д заасан зорилт- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.1, 6.3.7 дахь заалт- Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаал
2	Байршил	Нийслэлийн нийтийн тээврийн нэгдүгээр эгнээний зам (Цайзын уулзвараас Шархадны эцэс хүртэлх замын өргөтгөл шинэчлэлт)
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улсын төсөв
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Тооцоогоор үндэслэнэ.
5	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	2 үе шаттай 2023 он Нэгдүгээр шат Барилгажилтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эдийн засаг, хөрөнгө оруулалтыг нарийвчлан тооцоолсон Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргана. Төслийн урьдчилсан зураг төслийн хувилбарууд болон тайлангуудыг Нийслэлийн Замын хөгжлийн газарт танилцуулж, зөвшилцөнө. Хоёрдугаар шат Батлагдсан трассын дагуу зураг төслийг боловсруулна.

		<p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байр зүйн болон дэвсгэр зураг М1:1000; - Инженер-геологийн судалгааны дүгнэлт; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ; - Авто зам, замын байгууламж, гүүр, хиймэл байгууламжийн зураг; - Зургийн тайлбар бичиг (ус зайлуулах болон инженерийн байгууламжийн тооцоо, хучилтын тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, холбогдох захирамж, магадлалын ерөнхий дүгнэлт, техникийн нөхцөлүүд); - Инженерийн шугам сүлжээний зураг; - Техникийн шаардлага; - Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв магадлалаар оруулан баталгаажуулах;
6	<p>Зураг төслийг боловсруулахад ашиглах материал</p>	<p>Монгол Улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль - Хот байгуулалтын тухай хууль; - Авто замын тухай; - Газрын тухай хууль; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль - Усны тухай хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Гамшгаас хамгаалах тухай хууль; - Галын аюулгүй байдлын тухай хууль; - Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Барилгын тухай хууль; - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай; - Замын хөдөлгөөний дүрэм; - Бусад холбогдох хууль тогтоомж; <p>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичиг; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого; - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 2016 оны 52 дугаар тогтоол; - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 35 дугаар хурлаар дэмжигдсэн "Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний /концепц/ үзэл баримтлал"; - Үндэсний хөгжлийн газрын даргын 2020 оны А/56 дугаар тушаалаар баталсан "Төслийн техник эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх аргачлал"; <p>Норм, нормативууд:</p> <ul style="list-style-type: none"> - "Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016; - "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02;

		<ul style="list-style-type: none"> - “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04; - Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БНБД 31.101.04; - “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056-2009; - “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага” MNS 5682:2006; - “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12, “Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага” MNS 6808:2019; - “Авто зам, замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага” MNS 5683:2022; - “Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах; - ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”; - Бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх;
7	Баримт бичгийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> • Техник эдийн засгийн суурь судалгаа - Нөхцөл байдлын шинжилгээ - Тухайн газар нутгийн хүн ам, нийгэм эдийн засгийн судалгааг боловсруулах; - Гудамж замын сүлжээ, нийтийн тээврийн судалгааг боловсруулах; - Авто замын хөдөлгөөн эрчмийн судалгаа боловсруулах - Байгаль орчин, тохижилт, ногоон байгууламжийн судалгаа боловсруулах; - Газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын судалгаа хийх; - Инженер геологи, цаг уурын төлөв байдлын судалгаа хийх; - Инженерийн дэд бүтцийн судалгаа хийх; - Одоо байгаа зам замын байгууламж, инженерийн шугам сүлжээ дэд бүтцийг төсөлд ашиглах боломжтой эсэхийг тодорхойлох; - Төсөлд хамрагдаж буй нутаг дэвсгэрт урд өмнө боловсруулагдаж байсан хот байгуулалт, авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг судлан танилцаж, уялдуулах бололцоог тооцож тодорхойлно; - Одоогийн байдлын судалгаанд үнэлэлт, дүгнэлт өгөх. - Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолын тоо, хүчин чадал, чиглэлийн тооцоо боловсруулах ;

		<ul style="list-style-type: none"> - Инженерийн шугам сүлжээний нэгдсэн хонгилын системийн төлөвлөлт, хүчин чадал, хийц тодорхойлох - Ажиллах хүчний нөөцийг бүрдүүлэх хувилбаруудыг боловсруулах; - Нийгмийн болон эдийн засгийн үр ашгийн тооцоог нарийвчлан тооцох; - Байгаль орчинд ээлтэй, орчин үеийн дэвшилтэд техник технологийн талаарх судалгаа хийх, хэрхэн нутагшуулах чиглэлийг гаргах; • Инженерийн судалгааны тайлан: <ul style="list-style-type: none"> - Байр зүйн судалгааны тайлан; - Инженер-геологийн судалгааны тайлан; - Гол гудамж замын төлөвлөлт; - Туслах зам, дугуйн зам, явган хүний зам болон бусад замын байгууламжийн төлөвлөлт; - Төслийн бусад арга хэмжээний төлөвлөлт; - Төслийн нэгдсэн төсөв • Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, зөвлөмж: <ul style="list-style-type: none"> - Төслийг хэрэгжүүлэх газар зохион байгуулалт менежментийн төлөвлөгөө; - Төслийг хэрэгжүүлэх инженерийн хангамж, бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөө; - Төслийг хэрэгжүүлэх бусад арга хэмжээ; - Төслийг хэрэгжүүлэх нэгдсэн график төлөвлөгөө; • Төслийн санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ <ul style="list-style-type: none"> - Санхүү хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ - Эдийн засгийн үр ашгийн шинжилгээ • Эрсдэлийн шинжилгээ <ul style="list-style-type: none"> - Төслийн эрсдэлийн шинжилгээ гаргах - Төслийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах • Зураг төслийн иж бүрдэл <ul style="list-style-type: none"> - Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл; - Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто зам, замын байгууламжийн зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт); - Техникийн шаардлага; - Холбогдох шугам сүлжээний зураг төсөл, төсөв; - Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв; - Төслийн танилцуулга;
8	Гүйцэтгэгч байгууллага	<ul style="list-style-type: none"> - Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага - Судалгааны баг нь төслийн онцлогоос хамаарч хэдэн ч судалаачдын бүрэлдэхүүнтэй байж болох бөгөөд төсөл хэрэгжих салбарын технологи, удирдлага зохион байгуулалт, санхүү хөрөнгө оруулалт, эрсдэлийн чиглэлийн мэргэжилтнүүдтэй байна.
9	Захиалагч байгууллага	Нийслэлийн замын хөгжлийн газар

10	Зөвшөөрөлцөх байгууллага	<ul style="list-style-type: none"> • ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэх байгууллага - Хот байгуулалтын асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн хурал • Авто зам, замын байгууламжийн зураг төсөл зөвшилцөх байгууллага - Хот байгуулалт хөгжлийн газар - Нийслэлийн замын хөгжлийн газар - Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба - Нийслэлийн нийтийн тээврийн газар - Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төв - Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ - Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ - УБДС ТӨХХ - УБ ЦТС ТӨХК - ЦДҮС ТӨХК - МХС ТӨХК • Ажлын зураг төсөв - Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ
11	Боловсруулах хугацаа, тайлангийн бүрдэл	<p>ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ: Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулснаас хойш 60 хоног / магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэх хугацаа ороогүй болно/ Эхлэлийн тайлан: /20 хоногт гүйцэтгэнэ/ <ul style="list-style-type: none"> - Судалгаа, шинжилгээний ажил дууссан байх - Нэмэлтээр хийж гүйцэтгэх ажлын тоо хэмжээг гаргах; Дундын тайлан: /20 хоногт гүйцэтгэнэ/ <ul style="list-style-type: none"> - Эхлэлийн тайланд өгсөн санал, зөвлөмжийг тусгаж - Төлөвлөлтийн шийдэл, зураглалын ажлыг гүйцэтгэж дуусгасан байх - Хөрөнгө оруулалтын тооцоолол дууссан байх - Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, газар чөлөөлөлтийн зардлын тооцоо боловсруулах. - Хэрэгжүүлэх арга хэмжээ, менежментийг тодорхойлох; Эцсийн тайлан: /20 хоногт гүйцэтгэнэ/ <ul style="list-style-type: none"> - Санхүү хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ - Эдийн засгийн үр ашгийн шинжилгээ - Төслийн эрсдэлийн шинжилгээ гаргах - Төслийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ: ТЭЗҮ хүлээн авснаас хойш 60 хоног / магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэх хугацаа ороогүй болно/</p>
<p>12. Онцгой нөхцөл: Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулахад: - Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цэг байгуулах, замын төлөвлөлтийн дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох</p>		

- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө болон бусад баримт бичиг, шинээр төлөвлөгдсөн болон одоо байгаа авто зам, замын байгууламжтай уялдуулах
- Нийтийн тээврийн хэрэгслийг нэгдүгээр эгнээгээр зорчих боломжтой байхаар төлөвлөх, Нийтийн тээврийн газартай зөвшилцөх, нийтийн тээврийн терминалын төлөвлөлттэй уялдуулах
- Авто замын үндсэн элементүүд болох авто замын зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам /төслөөр/, уулзвар төлөвлөлт, гэрлэн дохио, автомашины зогсоол, явган хүний гарц, ногоон байгууламж, тусгаарлах зурвас, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх, план зурагт инженерийн шугам сүлжээний өөрчлөлт газрын нөлөөлөл, орчны мэдээллийг нэгтгэн боловсруулж үзүүлсэн байна.
- Явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн өнгө төрхийг тухайн орчны харагдах нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх.
- Хөндлөн огтлолыг орчны нөхцөлтэй уялдуулан төлөвлөх, барилга байгууламж, айлуудын орц гарцны шийдлийг оновчтой хийж хөндлөн огтлолыг төлөвлөх
- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх.
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах.
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, авто замын трассын дагууд суваг, шуудуу, жалга дайрсан үед шаардлагатай тохиолдолд гүүр, гүүрэн гарц, хоолой төлөвлөх
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. НЗХГ-ын Замын хөдөлгөөн төлөвлөлтийн хэлтэстэй хөдөлгөөн зохион байгуулалтын зургийг зөвшилцөх.
- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх
- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах.
- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг	1:500
Дагуу огтлол	хэвтээ 1:1000
	босоо 1:100
Хөндлөн огтлол	1:100
Уулзвар, огтлолцол	1:500
Бүтээц	1:20
- Тухайн зам, замын байгууламжийн үндсэн элементүүдийг Нийслэлийн авто замын бүртгэл мэдээллийн сангийн бүтэц бүрэлдэхүүний дагуу мэдээллийг боловсруулж цахим хэлбэрт замын шинж чанарын мэдээллийг үүсгэж "хотын замын мэдээллийн сан"-д оруулах, баталгаажуулах /хавсралтын дагуу боловсруулах/
- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг Хот байгуулалт, Хөгжлийн газрын "ТООН ЗУРГИЙН ТАНИХ ТЭМДЭГ"-ийн дагуу боловсруулсан байна.
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын

зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 2ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ архивт, орон зайн болон орон зайн бус мэдээллийг тоон хэлбэрээр мэдээллийн санд батлагдсан загварын дагуу хүлээлгэж өгөх.

ХЯНАСАН:

НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Г.Баттогтох

ТАНИЛЦСАН:


НБСШТ-ийн систем, динамик загварчлалын газрын захирал



М.Гэрэлт-Од

БОЛОВСРУУЛСАН:

НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн



Ц.Батжаргал

НБСШТ-ийн өгөгдөл мэдээллийн газрын өгөгдөл мэдээллийн ахлах шинжээч



Н.Баянмөнх

2023 оны ~~4~~...сарын ~~24~~...-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗАР

Газрын байршил

Нийслэлийн нийтийн тээврийн нэгдүгээр
эгнээний зам (Цайзын уулзвараас
Шархадны эцэс хүртэлх зам)

Газрын зориулалт

Авто зам, замын
байгууламж



Таних тэмдэг

— Төслийн байршил

Хянасан: *[Signature]* / Г.Баттогтох /
НЗХГ-ын БТХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.....
Танилцсан: *[Signature]* /М.Гэрэлт-Од/
НБСШТ-ийн систем, динамик загварчлалын газрын захирал
Боловсруулсан: *[Signature]* /Ц.Батжаргал/
НЗХГ-ын БТХ-ийн мэргэжилтэн
НБСШТ-ийн өгөгдөл мэдээллийн газрын
өгөгдөл мэдээллийн ахлах шинжээч *[Signature]* /Н.Баянмөнх/